



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Г Жендэрт суурилсан болон гэр бүлийн Г
хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний
2024-2027 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.4, 16.1.5, 16.1.6, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан 4.3.3, 4.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх "Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүйгээр ханган, олон улсын байгууллагын дэмжлэгийг авч ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), салбарын бодлого, хөтөлбөрт тусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг), шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, гүйцэтгэлийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Гэмтэл согог судлалын үндэсний төв (Э.Галбадрах)-д, статистик мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д ирүүлж байхыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Дүгнэлт бүхий тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т ирүүлэхийг Гэмтэл, согог судлалын үндэсний төв (Э.Галбадрах)-д, нэгдсэн статистик мэдээллийг боловсруулан Бодлого, төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг)-т ирүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141240447

Эрүүл мэндийн сайдын 2024 оны...
дугаар 03 сарын 05 -ны өдрийн...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
(2024-2027 он)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн." гэж, 16 дугаар зүйлд "иргэн" эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.", "Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална." гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." гэж тус тус зааж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (цаашид "ГБХТТХууль" гэж товчилно)-ийг анх 2004 онд баталж, 2017 онд шинэчлэн найруулсан. Уг хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч түүний гэр бүл, бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршдог.

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль, бусад холбогдох дүрэм журмын хүрээнд зохицуулсан.

Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхийн улс орон бүрд түгээмэл тохиолддог, удаан хугацаанд тасралтгүй үргэлжилдэг, хохирогчийн аж амьдрал, эрүүл мэнд, аюулгүй байдалд асар их хор хохирол учруулдаг олон нөхцөл шалтгаантай нийгмийн тулгамдсан асуудал юм.

Цагдаагийн байгууллагад 2023 онд 35574 гэмт хэрэг бүргэгдсэнээс хүний эрүүл мэндэд хохирол учруулсан 9393, хүчирхийлэх гэмт хэрэг 1460 бүртгэгдэж 76 хүн бэлгийн хүчирхийллийн хохирогч болж амь насаа алдсан нь 2022 оноос 14 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Иймд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх, хамгаалах ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн "Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2024-2027 оны төлөвлөгөө"-г боловсрууллаа.

Хоёр. Мандатын шинжилгээ:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үр дүн, үр ашиг ба тогтвортой байдлыг хангаж ажиллана.

2.1. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Хүн худалдаахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлтэй нягт хамтран ажиллана.

2.2.Төсөв санхүүгийн хүрээнд: Үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг үйл ажиллагааны санхүүжилт болон олон улсын байгууллагын төслийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд холбогдох тайлагналтыг Төсвийн тухай болон нягтлан болох бүртгэлийн тухай хууль, бусад тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллана.

Гурав. Арга хэмжээний зорилго, зорилт

3.1 Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллийг үнэлэх, хариу арга хэмжээ авах чадавх бүхий тогтолцоог бүрдүүлэх;

3.2 Нийгмийн эрүүл мэндэд хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах;

3.3 Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалсан өвчлөл, хүчирхийлэлтэй тэмцэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах.

Дөрөв. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

4.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1 Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, шүүмжлэхгүй байх;

4.1.2 Хүний эрх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад тэргүүлэх ач холбогдол өгөх, хохирогчийн аюулгүй байдлыг нэн даруй хангах, түүний амь нас, нууцлал, эрүүл мэндийг хамгаалах, тусламж, үйлчилгээний уялдааг хангах;

4.1.3 Хүн төвтэй, оролцогч талуудын хүчин чармайлт, оролцоо, хамтын ажиллагааг хангасан шийдвэр гаргаж, нотолгоонд тулгуурлах;

Тав. Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт

5.1 Арга хэмжээг 2024-2027 онд хэрэгжүүлнэ.

5.2 Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл

мэндийн газар төгдсөн удирдлага, төрөлжлийн арга зүйнээр хангаж, хэрэгжилтийг улсын хэмжээнд Эрүүл мэндийн яамны харьяа хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар зохион байгуулж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрийн болон төрийн бус эрүүл мэндийн байгууллага хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.3 Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар орон нутагтаа нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, үр дүнг тайлагнана.

Зургаа. Арга хэмжээний санхүүжилт

6.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

6.1.1 Улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2 Гадаадын зээл, буцалтгүй тусламж

6.1.3 Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

6.1.4 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж

6.1.5 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Долоо. Арга хэмжээний үр дүн

7.1 Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1 Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллийг үнэлэх, хариу арга хэмжээ авах чадавх бүхий тогтолцоо бүрдэнэ;

7.1.2 Нотолгоонд суурилсан тогтолцоог бий болгох, эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргахад нэгдсэн мэдээлэл, статистик тоо баримттай болж, эрсдэлийн үнэлгээ сайжирна;

7.1.3 Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалсан өвчлөл, хүчирхийлэлтэй тэмцэх, хариу арга хэмжээний чадавх сайжирна.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны..... дугаар сарын 23 өдрийн 05..... дугаар А/III тушаалын хоёрдугаар хавсралт

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ,
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2024-2027 он)

Зорилго: Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах										
Зорилт 1. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулах;										
Зорилт 2. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн нөлөөллийн талаарх тандалт судалгаа, статистик бүртгэлийг боловсронгуй болгож, нэгдсэн мэдээллийн сан байгуулах ;										
Зорилт 3. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүнийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;										
Зорилт 4. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.										
№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин				Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсөв
				2024 он	2025 он	2026 он	2027 он			
Зорилт 1. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулах;										
1.1	Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл болон мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулах	Батлагдсан журам	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	ЭМБ-уудын үзүүлэх тусламж, үйлчилгээний чиг үүргийг тодорхойлно	Тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсруулж батлуулна	Батлагдсан журмын дагуу тусламж үйлчилгээг үзүүлнэ	Батлагдсан журмын дагуу тусламж үйлчилгээг үзүүлнэ	ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ	ЭМБ-ууд ОУБ	Улсын төсөв, гадаадын зээл тусламж
1.2	Эмнэлэг түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-н стандартыг боловсруулж, батлуулах	Батлагдсан стандарт	Эрүүл мэндийн сайдын 2010 оны А/68 дугаар тушаал	Стандартын төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ	Стандартыг батлуулна	Стандартыг хэрэгжүүлнэ	Стандартыг хэрэгжүүлнэ	ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ, ГССҮТ	Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	Улсын төсөв, гадаадын зээл тусламж
1.3	Эмнэлэг түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж батлуулах	Батлагдсан журам	Эрүүл мэндийн сайдын 2010 оны А/68 дугаар тушаал	Бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмын төслийг боловсруулж, танилцуулна	Бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг төслийг батлуулна	Шинэчилсэн бүтцийн дагуу ажиллана	Журмын хэрэгжилтэд хяналт тавина	ЭМЯ-ны БТГ, ТЗУГ, СЭЗГ	Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	Улсын төсөв, гадаадын зээл тусламж
1.4	Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарын үндэсний	Батлагдсан стандарт, стандартыг нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо	-	ДЭМБ-ын баталсан ОУ-ын стандарттай уялдуулж үндэсний	Стандартын төслийг хэлэлцүүлж, батлуулна	Стандартын хэрэгжилтийг хангана	Стандартын хэрэгжилтэд хяналт тавина	ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ СХЗГ	Өмчийн бүх хэлбэрийн Эрүүл мэндийн байгууллага	Улсын төсөв, НҮБ-ХАС

	стандартыг боловсруулж, мөрдөх			стандартын төслийг боловсруулна						
1.5	Эмнэлэг түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс бусад нэг хүнд ногдох хувьсах зардлын өртгийг тооцож, санхүүжилтийг шийдвэрлүүлэх	Санхүүжилт олгох журам, санхүүжилтийн дүн	ХЗДХС, ЭМС, ХНХС-ын 2017 оны "Журам батлах тухай" А/80, А/132, А/60	Нэг хүнд ногдох хувьсах зардлын өртгийн судалгааг хийж, үр дүнг танилцуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлно	Санхүүжилт олгох журмын төслийг боловсруулж, хамтарсан тушаалыг батлуулна	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс бусад нэг хүнд ногдох хувьсах зардлыг олгоно	Үр дүнг тооцно	ЭМЯ-ны СЭЗГ, ЭМДЕГ ГССҮТ, Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	СЯ, ХНХЯ Бүх шатны ЗДТГ	Улсын төсөв, гадаадын зээл тусламж
1.6	Хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ (компьютер томограф, MRI)-г холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь даах нөхцөлийг бүрдүүлэх	Үнэ төлбөргүй тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо/хүйс	97 хүн буюу 7,5%	Шаардлагатай эрх зүйн бичгийг боловсруулж батлуулна	Тушаалыг хэрэгжилтийн хангана	Тушаалыг хэрэгжилтийн хангана	Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцно	ЭМЯ-ны СХГ, ЭТҮГ, СЭЗГ, ЭМДЕГ	ХЗДХЯ МУГХУСАЗЗ ГССҮТ ЭХЭМҮТ	ЭМДС
1.7	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн нөхцөл байдлын үед хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний бэлэн байдлын үнэлгээ хийх	Тусламж үйлчилгээний бэлэн байдлын үнэлгээний тайлан тархаасан байна	ЖСХ-тэй тэмцэх нь" гарын авлага 2021 он	Гамшигийн үеийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын үнэлгээг хийнэ	Үнэлгээний дүнг үндэслэн эрсдэлийн үеийн харилцаа холбооны журамд нэмж тусгуулна	Үндэсний сургагч багшийг бэлтгэнэ	9 дүүрэг, 21 аймагт бэлэн байдлын сургалт явуулна	ЭМЯ-ны ЭТҮГ, НЭМГ	ХЗДХЯ МУГХУСЗ ОБЕГ ЭМБ-ууд	Улсын төсөв, гадаадын зээл тусламж, НҮБХАС
1.8	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамж боловсруулж батлуулах	Шинээр батлагдсан үндэсний удирдамж	-	ДЭМБ-ын 7 шатлал дагуу тусламж, үйлчилгээний үндэсний удирдамжийг хэлэлцүүлж, батлуулна	Эрүүл мэндийн боловсрол олгох сургуулиудын бакалаврын хөтөлбөрт тусгана	Орон нутагт ажиллаж буй эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын 60 хувийг сургана	Орон нутагт ажиллаж буй эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын 100 хувь сургана	ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ	ЭЗХХЗГ ЭМДЕГ ЭМБ-ууд	Улсын төсөв, гадаадын зээл тусламж НҮБХАС
Зорилт 2. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн нөлөөллийн талаарх тандалт судалгаа, статистик бүртгэлийг боловсронгуй болгож, нэгдсэн мэдээллийн сан байгуулах										
2.1	Ажлын байран дээрх жендэрт суурилсан хүчирхийллийг судлах	Судалгааны тайлан, илрүүлсэн зөрчлийн хэлбэр/тоо	Эрүүгийн хууль	Эрүүгийн хуулиас ажлын байран дээрх бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдолд ял хүлээлгэх тухай зүйл, заалтыг хассан нь салбар дахь АББД-ын нөхцөл байдлыг судлана	Эмч, эмнэлгийн мэргэжилтний жендэрт суурилсан хүчирхийлэл, нийгмийн баталгаа, эрх тэгш байдлын судалгааг хийнэ	Ямар нөлөө үзүүлснийг судалгааны тайлан, зөвлөмжийг үндэслэн хариу арга хэмжээ авна	Хариу арга хэмжээг үнэлнэ	ЭМЯ-ны ТЗУГ, ҮСХ Аймаг, нийслэлийн ЭМГ	Бүх шатны ЭМБ ОУБ ТББ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
2.2	Эрүүл мэндийн үйлчилгээнд үйлчлүүлэгчийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, бие	Батлагдсан аргачлал	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Хүчирхийллийн шалтгааныг тогтоох аргачлалыг	Хүчирхийллийн шалтгааныг тогтоох аргачлалыг	Батлагдсан аргачлалын дагуу эрсдэлийн судалгаа хийнэ	Батлагдсан аргачлалыг үнэлж, үр дүнг тооцно	СЭМҮТ ГССҮТ ЭХЭМҮТ	НЭМҮТ ЦЕГ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ

	махбод, сэтгэл санаа, зан үйлийн өөрчлөлтийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах тандах, илрүүлэх, аргачлалыг боловсруулж, нэвтрүүлэх			боловсруулж, хэлэлцүүлнэ	батлуулж, хүний нөөцийг чадавхжуулна				Аймаг, нийслэлийн ЭМГ	
2.3	Нийгмийн эрүүл мэндэд хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн санд төвлөрүүлэх	Судалгааны тайлан, мэдээллийн санд төвлөрсөн статистик	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол гэмтлийн шалтгааныг судална	Хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, өвчлөлийн шалтгааныг судална	Олон улсын өвчний ангиллаар бүртгэлжүүлнэ	Холбогдох программ хангамжид нэмэлтээр оруулна	НЭМҮТ ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ	ЦЕГ ГССҮТ ЭХЭМҮТ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
2.4	Хүүхдийн байгууллагын орчин дахь жөндөрт суурилсан хүчирхийлэлд өртөх байдалд тандалт судалгааг хийх	Судалгааны тайлан, хариу арга хэмжээ	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он	2 дүүрэг, 2 аймгийн Ерөнхий боловсролын сургуульд тандалт, судалгааг хийнэ	4 дүүрэг, баруун болон хангайн бүсийн 4 аймгийн Ерөнхий боловсролын сургуульд тандалт, судалгааг хийнэ	3 дүүрэг, зүүн болон төвийн бүсийн 8 аймгийн Ерөнхий боловсролын сургуульд тандалт, судалгааг хийнэ	Тандалт, судалгааны тайлан, зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулна	СЭМҮТ НЭМҮТ ГССҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	ЦЕГ БЕГ ЭХЭМҮТ ЭМБ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
2.5	Эрэгтэйчүүд, хөвгүүд, бэлгийн цөөнх (ЛГБТ) жөндөрт суурилсан хүчирхийлэл амиа хорлох архидан согтуурах, мансуурах гэх мэт хорт муу зуршлын харилцан хамаарлыг судлах, хариу арга хэмжээг авах	Судалгааны үр дүн, хариу арга хэмжээ	Үндэсний статистикийн хорооны судалгаа 2018 он	ЖСХ амиа хорлох, донтох эмгэгт өртөх шалтгаан хамаарлыг судалж, танилцуулна	Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулна	Төлөвлөгөөний хэрэгжилт 80% хангагдана	Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьд хүргэж, хэрэгжилтийг үнэлнэ	СЭМҮТ НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	БСШУЯ МУГХУСА33 ЦЕГ ХГБХГ	Улсын төсөв ОУБ
2.6	Гэрийн асаргаанд байдаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх, эрт илрүүлэх, тандалт, судалгааг бусад салбарыг оролцуулан зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	-	Гэрийн асаргаанд байдаг иргэний судалгааг гаргаж, 1 дүүрэгт тандалт, судалгааг хийнэ	2 дүүрэг, баруун бүсийн 4 аймагт тандалт, судалгааг явуулна	3 дүүрэг, зүүн бүсийн 4 аймагт тандалт, судалгааг явуулна	3 дүүрэг, төвийн бүсийн 5 аймагт тандалт судалгааг хийж, үр дүнг танилцуулна	Геронтологийн үндэсний төв ХБХХДЕГ Аймаг, нийслэлийн ЗДТГ	ХЗДХЯ, ХНХЯ, ЦЕГ ГБХЗХГ ЭМБ, ОУБ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
2.7	Хүүхдийн болон ахмад настны халамж, асрамжийн төвд амьдарч байгаа байнгын эмчилгээ, асаргаа шаардлагатай хүүхэд, тусгай хэрэгцээтэй насанд хүрэгчдэд үйлчилгээ үзүүлдэг нэгжид далд хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа эсэхийг бусад салбарын оролцоотой тандах	Илрүүлсэн зөрчлийн тоо	-	Тандалт, судалгааг хамтран хийх байгууллагаа тодорхойлж, 2 асрамжийн төвд тандалт хийнэ	Тандалт судалгааг 4 асрамж, халамжийн төвд хийнэ	Тандалт судалгааг 6 асрамж, халамжийн төвд хийнэ	Тандалт судалгааг 8 асрамж, халамжийн төвд хийнэ	ЭМЯ-ны НЭМГ ГХУСА33АА ОУБ	ХЗДХЯ, ХНХЯ, БСШУЯ, ЦЕГ ГБХЗХГ Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ

2.8	Хүүхдийн байгууллагын багш ажилчдын зүгээс албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг зөрчих, хүүхэдтэй тэгш бус харьцах, тохуурхах, ялгаварлах, санаа бодлоо тулгах, ямар нэгэн зүйлээр дарамтлах зэрэг сөрөг нөлөөллийг тандах, судлах	Илрүүлсэн зөрчлийн тоо	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он	2 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад тандалт, судалгааг хийнэ	Баруун болон төвийн бүсийн хүүхдийн байгууллагад тандалт судалгааг хийнэ	Зүүн болон хангайн бүсийн хүүхдийн байгууллагад тандалт судалгааг хийнэ	Улаанбаатарын бүсийн хүүхдийн байгууллагад тандалт судалгааг хийнэ	СЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	ЦЕГ БЕГ ТББ Сурагчдын холбоо	Улсын төсөв, гадаадын зээл тусламж, НҮБХС ОУБ
2.9	Хүчирхийлэлд өртсөний улмаас төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж үйлчилгээ авсан тохиолдлыг бүртгэж, мэдээлэх, дагаж мөрдөх эрх зүйн актыг боловсруулж батлах	Баталсан журам	-	Өмчийн бүх хэлбэрийн ЭМБ-ын дагаж мөрдөх журмын төслийг боловсруулж, батлуулана	Н-Info программд мэдээллийн сан үүсгэх ажлыг эхлүүлнэ	Хүчирхийллийг илрүүлэх эмнэлзүйн үзлэгийн маягт болон пиктограмыг бүртгэл мэдээлэлд нэвтрүүлнэ	Мэдээллийн санд тогтмол баяжилт хийгддэг болно	ЭМЯ-ны БТГ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМБ-ууд	Улсын төсөв, гадаадын зээл тусламж, НҮБХС ОУБ
2.10	Жендэрт суурилсан хүчирхийллийн бүртгэл мэдээллийг олон улсын өвчний XI ангиллаар бүртгэж, нэгдсэн мэдээллийн санд нэгтгэх	ЖСХ-ийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн тоо мэдээ	ОУ-ын өвчний X ангилал	Оношийн бүлгийн ОУ-ын өвчлөлийн XI ангиллаар бүртгэж, эрүүл мэндийн анхан шатны бүртгэл мэдээллийн шинэчлэлд нэгтгэх	Холбогдох программ хангамжид нэмэлтээр оруулж, салбарын тайланд тусгана	Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын үндэсний судалгааг ҮСХ-той хамтран хийнэ	Жендэрт суурилсан тандалт, судалгаа, хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийн үндэсний цахим сүлжээг бий болгоно	ЭМЯ-ны БТГ, ЭМХТ	Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага	Улсын төсөв НҮБ-ХАС
2.11	Эрүүл мэндийн салбарын статистик бүртгэлийн эмхэтгэлд Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг бүртгэл, маягт мэдээ, мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах	Батлагдсан маяг	ЭМСЖЭТБХТ	Эрүүл мэндийн статистик мэдээллийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өөрчлөлт оруулах талаар санал оруулна	Эрүүл мэндийн үндэсний цахим системд хөгжүүлэлт хийнэ	Хүйсээр ангилан тайлагнаж, дүгнэдэг болно	Жендэрийн статистикт суурилсан шийдвэр гаргах нөхцөл бүрдэнэ	ЭМЯ-ны БТГ, ЭМХТ	ЖҮХАА ОУБ ЭМБ	Улсын төсөв ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
Зорилт 3.Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүнийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг үр чадварыг дээшлүүлэх;										
3.1	Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц үйлчилгээг нэвтрүүлэх	Багц тусламж, үйлчилгээг үзүүлэх ЭМБ-ын тоо	-	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад тусгана	Хүүхэд, өсвөр үеийн 1 кабинет, 1 эрэгтэйчүүдийн кабинетад нэвтрүүлнэ	Хүүхэд, өсвөр үеийн 5, эрэгтэйчүүдийн 1 кабинетад нэвтрүүлнэ	Хүүхэд, өсвөр үеийн 8, эрэгтэйчүүдийн 8 кабинетад нэвтрүүлнэ	ЭМЯ-ны БТГ, СЗЗГ, ЭМДЕГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Өмчийн бүх хэлбэрийн ЭМБ	Улсын төсөв, ОУБ
3.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хохирогчийг илрүүлэх, баримтжуулах, хамгаалах үйлчилгээ үзүүлэх сургалтыг	Хамгаалах үйлчилгээ үзүүлсэн хүний тоо/хүйс	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг 3 байгууллагын	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн 50 байгууллагын эмч, эмнэлгийн	6 аймгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, сувилагч	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн 80 байгууллагын	Аймаг, нийслэлийн ЭМГ,	СЭМҮТ ЭХЭМҮТ ЭМХТ ХХЭМБХолбоо	ОУБ ХХЭМБ

	холбогдох мэргэжилтнүүдэд явуулах			эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулна	мэргэжилтэнд сургалт явуулна	нарт сургалт явуулна	эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулна			
3.3	Хүүхэд өсвөр үе, оюутан залуучуудыг хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, зан үйлийн байдалд тандалт судалгааг хийх	Тандалт, судалгаанд хамрагдсан хүүхэд, өсвөр үе, оюутан, залуусын тоо/хүйс	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он	4 дүүргийн 3 их, дээд сургууль, ЕБС-ийн суралцагчдын хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэндийн байдалд тандалт судалгааг хийнэ	Баруун болон төвийн бүсийн 10 аймгийн хүүхэд өсвөр үеийн эрсдэлт зан үйлд үнэлгээг хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулна	Төлөвлөгөөг хэрэгжүүлж, өсвөр үе, оюутан, залуусын онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээг нэвтрүүлнэ	Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлнэ	НЭМҮТ СЭМҮТ ЭХЭМҮТ	ХГБХГ Аймаг, нийслэлийн ЭМГ ЭМБ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
3.4	Хүүхэд, залуучуудын дунд бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдалд тандалт судалгааг хийж, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүний тоо	-	Тандалт, судалгааг хамтран хийх байгууллагаа тодорхойлж, 1 дүүрэгт тандалт судалгааг хийнэ	1 дүүрэг, зүүн болон хангайн бүсийн 10 аймгийн хүүхдийн байгууллагад тандалт, судалгааг хийнэ	Төвийн болон баруун аймгийн хүүхдийн байгууллагад тандалт, судалгааг хийнэ	Улаанбаатарын бүсийн хүүхдийн байгууллагад тандалт, судалгааг хийнэ	ХӨСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Хариуцах байгууллагын төсөв, ОУБ
3.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх ажлыг явуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Тусламж, үйлчилгээний хүртээмжид үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж, хүргүүлэх	Нэг цэгийн үйлчилгээний төвийн ХБИ-дэд хүртээмжтэй, ээлтэй байдалд дүн шинжилгээ хийнэ	Сэтгэц, нийгмийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин бүрдүүлнэ	Сэтгэц, нийгмийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин бүрдэнэ	СЭМҮТ ГССҮТ, Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ	ХБХХГ Бүх ЭМБ	ОУБ
3.6	Нэг цэгийн үйлчилгээний төв, хамтарсан багт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний үр чадварыг дээшлүүлэх, чадавжуулах	Бэлтгэсэн албан хаагчдын тоо/хүйс	2 удаагийн давтан сургалт	2 дүүргийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд чадавжуулах сургалт явуулна	2 дүүрэг, баруун бүсийн 4 аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулна	2 дүүрэг, зүүн бүсийн 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулна	2 дүүрэг, төвийн бүсийн 4 аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулна	ГССҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ-ууд	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
3.7	Хүмүүсийн бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийлэл зэргээр ялгаварлан гадуурхалтыг хориглох, тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, хандлагыг сайруулах	Албан хаагчдын тоо/хүйс	Хүний эрхийн конвенц	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ажилчдад сургалт явуулна	2 дүүрэг, баруун бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	4 дүүрэг, зүүн бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	2 дүүрэг, хангайн бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Бүх ЭМБ, ОУБ	Хариуцах байгууллагын санхүүжилт, ОУБ
3.8	Жендэрт хүчирхийлэлд өртсөн, өртсөний дараах эрүүл мэндийг нь хамгаалах, хариу арга хэмжээний талаар өндөр хөгжилтэй орны	Бэлтгэсэн албан хаагчдын тоо/хүйс	1 хүн	2 мэргэжилтэн сургасан байна	4 мэргэжилтэн сургасан байна	6 мэргэжилтэн сургасан байна	8 мэргэжилтэн сургасан байна	ЭМЯ-ны ТЗУГ	ЖУХ ОУБ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ

	тэргүүн туршлагаас суралцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх									
3.9	Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэнд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй тохиолдлыг таньж мэдэх, илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ур чадвар эзэмшүүлэх	Бэлтгэсэн албан хаагчдын тоо/хүйс	150 хүн	1 дүүрэг, баруун бүсийн 4 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	2 дүүрэг, зүүн бүсийн 10 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	4 дүүрэг, төвийн бүсийн 10 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	1 дүүрэг, хангайн бүсийн 8 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	ГССУТ ЭМХТ НЭМУТ ЭХЭМУТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ ЗХЖШ	ДЭМБ, НУБ-ХАС ОУБ
3.10	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламжийн багц үйлчилгээг нэвтрүүлж, хэрэгжүүлэх	Багц тусламж, үйлчилгээг ЭМБ-ын тоо	-	Хүчирхийлэлд өртсөний дараах эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг тодорхойлно	Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлнэ	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүр ЭМЗШТ-ын багц үйлчилгээг үзүүлдэг болно	Хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийнэ	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар	Бүх шатны Засаг дарга ЗХЖШ	Тухайн байгууллагын төсөв
3.11	Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад нийгэм, сэтгэц-зан үйлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх арга барилд сургах	Бэлтгэсэн албан хаагчдын тоо/хүйс	-	1 дүүрэг, 2 аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	2 дүүрэг, баруун бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	4 дүүрэг, зүүн бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	1 дүүрэг, хангайн бүсийн аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт явуулна	СЭМУТ НЭМУТ АШУУИС	Аймаг, нийслэлийн ЭМГ ЭХЭМУТ ЭНЭУТ-2	Хариуцах байгууллагын төсөв, ОУБ
3.12	Эрүүл мэндийн боловсрол олгодог их дээд сургуулиудын төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрт гендерийн ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний удирдамжийг тусгах	Тусгагдсан хөтөлбөрийн тоо	-	Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрүүдэд үнэлгээ хийнэ	ЖСХ-ын хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдамжийг төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт тусгана	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжил олгох сургалтын хөтөлбөрт ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний удирдамжийг тусгана	Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил олгох сургалтын хөтөлбөрт ЖСХ-ийн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний удирдамжийг тусгана	ЭМЯ-ны ТЗУГ, ЭМХТ, ЭМШУИС	БСШУЯ	НУБХАС
Зорилт 4. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах										
4.1	Хүүхдийн эсрэг үйлдэгдэх хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, хүчирхийллээс сэргийлэх орчин бүрдүүлэх ухуулга, нөлөөллийг ажлыг зохион байгуулах	Ухуулга, нөлөөллийн ажлын тоо	-	Хүүхдийн байгууллагын ажилчдын мэдлэг хандлагыг үнэлж, 2 дүүрэгт нөлөөллийн ажил явуулна	баруун бүсийн 5 аймаг, 2 дүүрэгт нөлөөллийн арга хэмжээг явуулна	Зүүн болон хангайн бүсийн 10 аймаг, 2 дүүрэгт нөлөөллийн арга хэмжээг явуулна	Төвийн бүсийн 10 аймаг, 3 дүүрэгт нөлөөллийн арга хэмжээг явуулна	НЭМУТ ГССУТ ЭХЭМУТ СЭМУТ	БСШУЯ ХНХЯ МУГХУСАЗЗ ЦЕГ ХГБХГ Аймаг, нийслэлийн ЗДТГ	ДЭМБ, НУБ-ХАС ОУБ

4.2	Нэг цэгийн үйлчилгээний төв, асрамжийн газар, хүүхдийн байгууллагад ажиллаж буй багш, ажилчдад хохирогчтой хэрхэн зөв харьцах чадамж эзэмшүүлэх сургалтыг явуулах	Хамрагдсан хүний тоо/хүйс	-	-	2 дүүрэг, баруун бүсийн аймгуудын хүүхдийн байгууллагын багш, ажилчдад сургалт явуулна	3 дүүрэг, зүүн болон хангайн бүсийн аймгуудын хүүхдийн байгууллагын багш, ажилчдад сургалт явуулна	3 дүүрэг, төвийн бүсийн аймгуудын хүүхдийн байгууллагын багш, ажилчдад сургалт явуулна	СЭМУТ ГССУТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	БЕГ ЦЕГ ЭХЭМУТ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
4.3	Багш, сурган хүмүүжүүлэгч нарт жеңдэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зан үйлийн сургалтыг явуулах	Хамрагдсан хүний тоо/хүйс	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он	1 дүүрэг, хүүхдийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулна	2 дүүрэг, баруун болон зүүн бүсийн 10 аймгийн хүүхдийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулна	2 дүүрэг, төвийн бүсийн 10 аймгийн хүүхдийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулна	3 дүүрэг, хангайн бүсийн 5 аймгийн хүүхдийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулна	СЭМУТ ГССУТ НЭМУТ Аймаг, нийслэлийн ЗДТГ	БЕГ ЦЕГ ЭХЭМУТ	Хариуцах байгууллагын төсөв, ОУБ
4.4	Жеңдэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж буй этгээдтэй ажиллах, харьцах эрүүл мэндийн ажилчдад зориулсан метофор сэтгэл зүйн картын сургалт зохион байгуулах	Хамрагдсан хүний тоо/хүйс	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он	Сэтгэцийн эрүүл мэнд судлалаар үндсэн мэргэшил эзэмшсэн 30 эмчийг сургалтад хамруулна	Эх барих эмэгтэйчүүдийн 40 эмчийг сургана	40 хүүхдийн эмчийг сургана	Гэмтэл согог судлалын 40 эмчийг сургана	ЭМЯ, СЭМУТ ГХУСА33АА	ХЗДХЯ, ШШГЕГ	Улсын төсөв, ОУБ
4.5	Хүчирхийллийн хохирогч болох, нэн ялангуяа хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх олон нийтэд чиглэсэн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1 дүүрэг, 2 аймгийн хүүхдийн байгууллагад урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулна	3 дүүрэг, төвийн болон зүүн бүсийн 10 аймгийн хүүхдийн байгууллагад урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулна	3 дүүрэг, баруун болон хангайн бүсийн 10 аймгийн хүүхдийн байгууллагад урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулна	Зохион байгуулсан арга хэмжээг дүгнэж, үр дүнг тооцно	ЭХЭМУТ ГССУТ ЭХЭМУТ ХХГХУСДЗ Аймаг, нийслэлийн ЭМГ	БСШУЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ Бүх ЭМБ	Хариуцан хэрэгжүүлэх байгууллагын төсөв, ОУБ
4.6	Шинээр гэр бүл болж буй залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, жеңдэрт суурилсан хүчирхийлэлээс ангид байх, МСС, нөлөөллийн ажлыг явуулах	Сургалт, арга хэмжээний тоо	-	1 дүүргийн ЭМТ-өөр үйлчлүүлсэн шинэ, залуу гэр бүлд ЖСХ-ээс ангид байх сургалт, нөлөөллийн ажлыг явуулна	2 дүүрэг, баруун бүсийн аймгуудын шинэ, залуу гэр бүлд сургалт явуулна	4 дүүрэг, зүүн болон хангайн бүсийн аймгуудын шинэ, залуу гэр бүлд сургалт явуулна	3 дүүрэг, төвийн бүсийн аймгуудын шинэ, залуу гэр бүлд сургалт явуулна	Аймаг, нийслэлийн ЗДТГ	ЦЕГ ЭХЭМУТ ЭМБ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
4.7	Сургуулийн орчинд үйлдэгдсэн хүчирхийлэл, дарамтад өртсөнийг илрүүлэх, мэдээлэх журмыг хүүхдийн байгууллагын нийгмийн ажилтан, багш, сургуулийн эмч, сэтгэл зүйч нарт танилцуулж, чадавхжуулах сургалт явуулах	Хамрагдсан хүний тоо/хүйс	Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа	1 дүүргийн хүүхдийн байгууллагын эмч нарыг сургаж чадавхжуулна	баруун бүсийн аймгууд, 2 дүүргийн хүүхдийн байгууллагын багш нарт сургалт явуулна	зүүн болон хангайн бүсийн аймгууд, 4 дүүргийн хүүхдийн байгууллагын багш нарт сургалт явуулна	Төвийн бүсийн аймгууд, 3 дүүргийн хүүхдийн байгууллагын багш нарт сургалт явуулна	Аймаг, нийслэлийн ЗДТГ НЭМУТ	ЦЕГ ЭХЭМУТ ГССУТ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
4.8	Хүчирхийлэлд өртсөн хохирогчийн гэр бүл, гэр гишүүдэд	Хамрагдсан аймаг, дүүрэг, хүний тоо	-	2 ЭМБ-аар үйлчлүүлсэн иргэдэд зөвлөгөө,	Баруун бүсийн аймгуудад болон	Зүүн болон хангайн бүсийн аймгууд болон 4	Төвийн бүсийн аймгууд болон	СЭМУТ НЭМУТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ

	хүчирхийлэлд өртсөн хохирогчтой хэрхэн харьцах зөвлөмж өгөх сургалт явуулах			мэдээллийг хүргэнэ	2 дүүрэгт сургалт явуулна	дүүрэгт сургалт явуулна	3 дүүрэгт сургалт явуулна		ЭМБ-ууд	
4.9	Хот, суурин газарт шилжин суурьшигчдад гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх эрүүл мэндийн боловсрол олгох	Хүний тоо/хүйс	-	1 аймаг, 1 дүүрэг, шилжин ирж буй цэргийн албан хаагчдад сургалт явуулна	4 аймаг, 2 дүүрэг, ирж буй цэргийн албан хаагчдад сургалт явуулна	5 аймаг, 2 дүүрэг, ирж буй цэргийн албан хаагчдад сургалт явуулна	10 аймаг, 3 дүүрэг, ирж буй цэргийн албан хаагчдад сургалт явуулна	ЭМЯ Аймаг, нийслэлийн ЭМГ ЗХЖШ	ЭЭХХЗГ ЭМДЕГ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-2	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ
4.10	Хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аянд нэгдэх, олон нийтийн мэдээллийн сүлжээтэй хамтран ажиллах	Аяны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	10 үйл ажиллагаа	12 үйл ажиллагааг явуулна	14 үйл ажиллагааг явуулна	15 үйл ажиллагааг явуулна	15 үйл ажиллагааг явуулна	Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд ЗХЖШ	ЖҮХ Аймаг, нийслэлийн ЗДТГ ТББ	ДЭМБ, НҮБ-ХАС ОУБ

Товчилсон нэрийн жагсаалт:

ХЗДХЯ - Хууль зүй, дотоод хэргийн яам;
ЦЕГ - Цагдаагийн ерөнхий газар;
ШШГЕГ - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар;
ОБЕГ - Онцгой байдлын ерөнхий газар;
МУГХУСАЗЗ - Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл;
ХХГХУСДЗ - Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл
БСШУЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
БЕГ - Боловсролын ерөнхий газар
ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
ХГБХГ - Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;
ЭМЯ - Эрүүл мэндийн яам;
ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ - Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар;
ЭМЯ-ны СЭЗГ - Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар;
ЭМЯ-ны НЭМГ - Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар;
ЭМДЕГ - Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар;
ЭЭХХЗГ - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар;
ГССҮТ - Гэмтэл, согог судлалын үндэсний төв;
ЭХЭМҮТ - Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв;
ЭНЭҮТ - Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2;
ЭМГ - Эрүүл мэндийн газар;
ЭМБ - Эрүүл мэндийн байгууллага;
ЭМДС - Эрүүл мэндийн даатгалын сан

ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн хурал;
ЗДТГ - Засаг даргын Тамгын газар;
СХЗГ - Стандарт, хэмжил зүйн газар
ДЭМБ - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага;
НҮБ-ХАС - Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан;
ОУБ - Олон улсын байгууллага;

Товчилсон үгийн жагсаалт

ЭМСЖЭТБХТ - Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөө
ЭМЗШТ - Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж